

Эшлэл, зүүлт

1. Ж.Неру Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. УБ. 1989, б.2, т.63
2. Мөн тэнд т.63
3. Мөн энд т.63-64
4. Бабур. Записки Бабура. Ташкент., 1958, с.304
5. Антонова К.А. Очерки общественных отношений и политического строя Могольской Индии времен Акба: а (1556-1605) М., 1989, б.2, т.68
6. Ж.Неру, Ертөнцийн түүхийг сөхвөл.. 5 .1989, б.2, т.68
7. История Индии в средние века, М., 1968, с.550 8. Мөн тэнд с.553, с.557

АЛТАН СУРГААЛИЙН
ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

А. Төмөрцэрэн

XIX зууны эцэс XX зууны эхэн үед Монгол оронд колонийн болон (феодалын дарлалыг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөж эхлэв. Үүнийг дагалдан монголын уран зохиол ардчилсан чиглэл далайцтай хөгжих боллоо. Үүний нэг жишээ нь олон түмний дунд “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” гэж алдаршсан шүлэглэсэн зохиол болно. Алтан сургаал зохиолыг дотоод гадаадын монголч эрдэмтэд удаа дараа судалсаар ирсэн.⁽¹⁾ Мөн 1913 оноос эхлэн дотоод гадаадад энэ зохиолыг хэвлэн нийтэлсэн нь арваад тоонд хүрч байна.⁽²⁾ Мөн гар бичмэлээр дэлхий дахины номын санд цөөнгүй байдгийг ном зүйн бүртгэлээс үзэж болно. Сүүлийн үед уг зохиолын зохиогчийн тухай асуудал анхаарал татах боллоо. Уг асуудлыг хөндөхийн тулд уг зохиолын анхны хэвлэлээс авч үзье.

Энэ зохиол 1913 онд Нийслэл хүрээнд “Ерэн хоёр шүлэгт дөрвөн бүлэгтэй шинэ зохиолын сургаал” гэсэн нэртэйгээр анх хэвлэгдсэн бололтой. Гэвч энэ анхны хэвлэл Улсын Төв номын сан болон эрдэмтэн мэргэдийн хувийн номын сангаас ухаанбаатарт олдохгүй байна. Дани улсын Копенгагены номын санд “Ерэн хоёр шүлэгт дөрвөн бүлэгтэй шинэ зохиолын сургаал” гэсэн нэртэй байдгийг Герман улсын монголч эрдэмтэн В.Хайссит “Монголын уран зохиолын түүх” хоёрдугаар ботийн 588-р талд тэмдэглэсэн байна. (Висбаден, 1972). Үүнээс гадна эрдэмтэн В.Хайссиг, Английн монголч эрдэмтэн Ч.Бауден хоёрын 1971 онд Копенгагенд хэвлүүлсэн “Монгол гар бичмэл, модон барын номын каталог” гэсэн нэр бүхий Копенгагены номын бүртгэлийн 62-63-р талд уг зохиолын нэгэн сонин хувилбар байдгийг тэмдэглэжээ. Уг зохиолын эхний нүүрэнд нь: “Зарлигаар соёрхсон буян ивээгч сүмийн гэгээний айлдсан гүнгийн зуугийн гэгээний сургаал оршив” гэж бичсэн атал зохиолын

төгсгөлд: нийт таван бүлэг хэмээн номлосон мэргэн сургаал үнийг шинэ толийн хорооноос хэвлэн тараав гэсэн байна.

1912 онд Цахарын Жо амбан (М.Жодовжав) Цахарын сүрэг хошуунд багтаж агсан Даригангын сүрэг хошууг хамгаалан. Ар монголын цэрэгтэй тулалдаж хөл нь шархдаад фронт дээр арваад цэргийн хамт олзлогдон, нийслэл хүрээнд хүргэгдэн ирээд 1915 онд орон нутагтаа буцсан билээ. Нийслэл хүрээнд гэрийн хорионд байхдаа Алтан сургуул шүлгийг бичиж 1909-1910 оны үед Өвөр Монголд танил болсон Цэвээн Жамцаранод өгч Шинэ толийн хороонд хэвлүүлжээ. Уг шүлэг нийтдээ 16 бүлэг гэгдэх боловч одоо 13 бүлэг нь олдож хэвлэгдсэн. Эхлээд зөвхөн 4 бүлгийг нь хэвлэсэн бололтой. Сургууль шүлгийн зохиогчийн нэрийг тавьж болохгүй байсан. Учир нь зохиогч нэг ёсондоо хоригдлын байдалтай гэрийн хорионд байсан. Нөгөө талаар монголын ихэс дээдэс, хар шар феодалын гэм буруу, сүүдэртэй талыг хурцаар илчлэн шүүмжилсэн нь ийм зохиолын зохиогч болон тодрох нь өөр нь элдэв бэрхшээл учруулах үүд нээгдэх нь аяндаа тодорхой биз ээ. Ийм учраас алтан сургаал эхлээд зохиогчийн нэргүй “Ерэн хоёр шүлэгт орвон бүлэгтэй шинэ зохиолын сургаал гэж хэвлэгдсэн байна. Гэтэл удалгүй эрхэм дээдсээ элдвээр хэлсэн энэ шүлгийн зохиогчийг тодруулан гаргах зэрэг асуудал Цэвээн гуайд тулгагдан иржээ. Асуудал ийм болохын хамт эрдэмтэн Цэвээн Жо амбантай зөвлөлдөн 1907 онд нас нөгцсөн Гүнгийн зуугийн гэгээн Иишданзанван жил зохиосон юм гэж зохих газар мэдүүлэн анхны хэвлэлийг хураан авч засвар хийсэн байдалтай байна. Тийм учраас энэхүү шүлэг чинь тодорхой зохиосон эзэнтэй гэсэн санааг л тод болгохын тулд зөвхөн эхний нэгдүгээр бүлэгт зохиогчийн нэр гурав дахин гарна. Жишээ нь 1928 онд Улаанбаатарт хэвлэсэн “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал нэгэн дэвтэр оршив” зохиолын 1-2 талд:

Ишданзанванжил гэдэг Гүнгийн зуугийн Шавран бий.

Мөн зохиолын 3-р талд:

Данзанванжил дарвиглах нь даанч баахан хэтэрхий байна. Мөн зохиолын 8-р талд: Магад мунхаг Данзанванжил мань тэнэг болтугай:...гэжээ. Хуучны монгол зохиолд зохиогчийн нэр төгсгөлд нь ганц дурдах төдий өнгөрдөг дэгтэй байж билээ.

Сайн ноён хан Намнансүрэнгийн бичээч явсан хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Б. Баяр гуай 1970-аад оны үед ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Содном, Х.Пэрлээ, Д.Цэнд, Ж.Төмөрцэрэн нарт: Энэ зохиолыг чинь Цахарын Жо амбан зохиосон юм. Эхэлж хэвлэхдээ одоогийнхоос өөр нэртэй байсан юм гэж хэлж байсан нь чухам байдалтай нийцсээр байна. 1994 оны хавар хуучин ном зохиолын баялаг цуглуулгатай өндөр настан Цэвэгдорж гуайгаас (Ард кино театрын дарга агсан) алтан сургаал шүлгийн анхны Хэвлэлийг уншуулахыг хүсэхэд: Тэрний түрүүчийн хэвлэл нь хураагдсан юм шиг санагдааг байна. Надад 1928 оны хэвлэл байна. Уншвал авч унш гэж байж билээ. Эл байдал уг зохиолын анхны хэлэлийг олон талаас нь нарийвчлан судлах ажил зүй ёсоор шаардагдаж буйг харуулж байна. Копенгагенд бүхий алтан сургаал зохиолын хувилбарууд эл байдлыг илчилж байна. “Ерэн хоёр шүлэгт

дөрвөн бүлэгтэй шинэ зохиолын сургаал” гэгчээ хурааж аваад “Зарлигаар соёрхсон буян ивээгч сүмийн гэгээний сургаал оршив” гэсэн нэр өгч бас тавдугаар бүлэг гэж маш товч бүлэг яаравчлан бичиж хавсаргасан бололтой.

Одоо уг зохиолын агуулгад хийсэн дүн шинжилгээнээс ажиглан үзье.

Өвөр монголын эрдэмтэн Ринчингаваа “Монгол бичгийн соёлын түүхийн туршилт тэгүхэ” (Хөх хот. 1990) хэмээх зохиолын 347 дахь талд сургаал шүлгийн тухай ийнхүү тэмдэглэжээ.

Аван зүгийн их орон таван жэу (тив)-ийн дотор
 Ардын эрх байгуулсан намын хурал болно
 Алдаршсан улс орон арвин гэх боловч
 Анх манай дунд уос дөрвийн дүншүүр
 Иргэн. Манж. Монгол. Хотон дөрвөн аймаг нийтээр
 Илэрхийеэ энэ цагийн таван их угсаа
 Эзэн төр буурч намын хурал болоод
 Эрдэмтдийг өргөмжлөн ард төр байгуулна

гэх мэтийн бадаглалаас үзвэл яг 1911 онд Манж Чингийн төр эцэслэж, иргэн улс байгуулсны дараах (үеийн) бүтээл мэт байна. Үүнд 1907 онд нас барсан Ишданзанванжил 1911 оны дараа болсон хэрэг явдлыг хэрхэн бичих вэ? гэсэн асуулт аяндаа гарч байна” гэжээ. Энэ бол үнэхээр Ишданзанванжил бичиж болшгүй бадаг мөн.

1928 онд Улаанбаатарт хэвлэгдсэн “Гүнгийн зуугийн гэрээний алтан сургаал нэгэн дэвтэр оршив” гэдэг зохиолын 15-р талд бүхий

Гадаад монгол төрийн үнэн цагаан боолыг
 Ганц биеийн өмч мэт эндүүрэл болгоод
 Гасалгах бүрэлгэх мөлжихөд шунагч
 Гамшиг унал тэнгэрээс цаазтай биш үү

гэсэн энэ бадгийг эрдэмтэн Я. Баатар 1994 оны 5-р сарын 7-ны “Улаанбаатар” сонины № 86/545 дугаарт үндсэндээ зөв тайлбарласан. Ишданзанванжил хувилгаан өөрийгөө ямар ч нөхцөлд боол гэж хэлэх ёсгүй. Жо амбан сургаал шүлэгтээ өөрийгөө “төрийн үнэн цагаан боол” Богд хааны засгийн газарт бичсэн өргөдөлдөө “өчүүхэн боол” гэж бичсэн байж билээ.

Сургаал шүлгийн дотор ХХ зууны эхэн үеийн монголын улс нийгмийн амьдрал байдлыг нэлээд өргөн хүрээтэй олон талаас авч үзсэн байдаг. Эдгээрийн дотроос юуны өмнө шар хар феодалын эрхэмсэг ихэмсэг байдлыг илчлэн шүүмжилсэн, нийгмийн доторхи ариун ёс, хэв хууль, хүний эрх зүйг бүдүүлгээр зөрчин буй ёс бус үйл ажиллагааг уудлан гаргасан, элдэв этгээд муухай явдлыг хошигнон дүрсэлсэн зэрэг ардчилсан үзэл санаагаар баялаг бөгөөд нийгмийн үнэн шудрага ёсны төлөө тэмцэгч дэвшилт утга агуулгаар баялаг байдгийг судлагчид удаа дараа онцлон тэмдэглэсээр иржээ.

Зохиолын дотор дам хуврагийн анхаарах ёсгүй эцэг эхээ ачлан асрах дахимдагуу ёсон, өрх гэр, эр эмийн дүрэмт харьцаа, хүүхэд багачуудаа хүмүүжүүлэн сургах арга хэлбэр, иргэн хүний төрдөө хүлээх эрх үүрэг...зэрэг төр ёсны олон асуудлыг хөндөн бичжээ.

Уг зохиолын дотор бурхан шашны номлолд огт эрхэмлэн үздэггүй богд Күнзийн номлол, таван ном, дөрвөн бичиг, богдын сургаалыг

сэнхүүлэн бадруулсан бичиг...тэргүүтнийг эрхэмлэн хүндэтгэсэн байдаг.

Шэнжзүү хуанди богд хаадын зохиож гаргасан

Шэн юй гуан шюн хэмээгдэх 16 бүлэг

Шинэ цагийн бодрол ба сэтгүүл бичгүүдийг

Шаламгайлан аль сайтуур үйлдвээс зохино.

Туйлын богд Күнз хийгээд дөрвөн богдын зохиол

Дөрвөн бичиг түүнчлэн таван ном үлэмж

Түмэн оны түүх намтар утга шүлгүүд ба

Төр ёс хууль цааз бүхэн төгс байна гэжээ. (Ишданзанванжилын шүлгүүд, Бээжин, 1984 он, 105-р талд)

Алтан сургаалын зохиогч тэр цагт монгол үндэстний хувь заяа түгшүүртэй болж, үндэстний хүч чадал илэрхий доройтон, ард түмний амьдралын үндэс болсон газар нутаг чухалдан буй зэрэг улс төр, эдийн засгийн амин чухал асуудлыг тэр цагийн Хан, ван... нарт хандан дэвшүүлэн тавьсан байдаг.

Гадаад аймаг олон монгол чуулган хошууд

Харшилдах цагийн байдал хувьсгалыг үзэж

Хамаг монгол угсаагаа тэтгэмжилж хайрла...

Муу зусар хорсолт харийн эзэрхэг

Манай монгол буурахын цаг болоод

Маш ховдог уран арга мэх хэрэглэн

Магадаар эзлэхийн тохиолд хүрчээ.

Харийн харгис ойртвол хорлол дайсан болно.

Газар нутаг чухалдвал ард үл тогтоно.

Хамаг түмэн үймбэл хамт зовол амсана.

Хайр өршөөл үзүүлж иргэдээ хамгаал! гэжээ. (Ишданзанванжилын шүлгүүд, Бээжин, 1984 он, 114-115-р талд).

Ийнхүү уг зохиолын агуулгаас үзэхэд төр ёсны боловсрол олсон хүний зохиолын шинж илрэхээс бус улс нийгмийн амьдралаас ангид бурхан шашны номын мөр хоосон лам хувраг хүний зохиолын шинж бус болох нь мэдэгддэг юм.

Ер нь Ордосын Ишданзан хувилгаан монголын хар шар феодал, улс нийгмийн байдлыг тийнхүү хурцаар шүүмжлэх үзэл санаа төрсөн гэхийг итгэхэд бэрх юм. Учир нь нэг хийдийн гэгээн хувилгаан гэгч нь өндөр эрх ямба эдэлсэн том феодал хүн байдаг шүү дээ. Харин Жо амбан бол үүнээс өөр юм. Энэ бол Цахарын сүрэг хошууны нийтийн дарга байсан. Хуучин цагт монголын хошуудыг гурван түвшинд ялган хэлэлцэж болно. Ар тавин зургаа, өвөрр дөчин ес гэж ярьдаг монголын засаг хошууд, ноёд түшмэдийн эрх дарх, ямба хэргэм туйлын өндөр, язгуур тодорхойлон шарх тушаал эзэмшдэг байлаа. Үүнээс нэлээд ялгаатай нь Цахарын цэргийн найман хошуу, Хөлүн буйр, баргын цэргийн найман хошууд орно. Энд үе улиран залгамжилдаг шарх зэрэг, тайж хамжилга гэж байхгүй. Цахарын сүрэг хошууны ноёд эрүүгийн хууль зөрчсөн иргэдийг шүүх эрх ч байдаггүй хамгийн бага эрх ямба эдэлдэг байлаа. Иймээс Өвөр Монголд Баруунзүүн Сөнидөд хүн болж төрөхөөс Барга Цахарт очиж тэмээ болж төрье гэсэн хууч үг байсан билээ. Энэ уг нь зөвхөн Сөнид хошуунд холбогдох уг биш, засаг хошуунд нийтэд холбогдох үг болно. Сүрэг хошууны иргэн агсан

Жо амбанд шашин төрийн эрх ямбыг хослон эдлэдэг Их хүрээний феодал ноёд гойд хачин харагдсан байлгүй. Нөгөө талаар 1912 оны өвөл шүүх яамнаас: “Чи монгол үндэс угсааны хүн атлаа Богд хаант Монгол улсдаа зэвсэг барин халдсан ялт этгээд” хэмээн хэрэг тулгахад Жо амбан хариуд нь: “Богд хаант Монгол улсад халаагүй. Зөвхөн дээд газрын шийдвэрээр өчүүхэн боол миний бие өөрийн харъяа Дарьгангын сүрхий хамгаалах үүргийг гүйцэтгэсэн” хэмээн мэдүүлэг өгсөөр нэлээд хугацаа өнгөрчээ. Гэвч уг байдлыг нарийвчлан үзвэл Жо амбан сүрэг хошууны нийтийн дарга мөн бөгөөд түүний эрх мэдэл хязгаарлагдмал. Өөрийн мэдэлд байнгын цэрэг байхгүй, дээд газрын шийдвэрийг биелүүлэн яваа доод тушаалын түшмэл мөн тул хориод хоноод түүнийг шоронгоос гаргаж, гэрийн хорионд суулгасан байна. 1914 онд Богдын засгийн газраас Жо амбан тэргүүтэй дайны олзлогсодтой ял хэлэлцэхгүй болж орон нутагт нь буцаахаар шийджээ. Гэвч амьдралд тохиолдсон эл явдал түүний зохиолд нөлөөлөхийг үгүйсгэхийн аргагүй.

Одоо уг шүлгийн зохиогч гэж үзэж байгаа. Жо амбаны тухай хэдэн үг тэмдэглэе. Мижигсэнгэ овогтой Жодовжав 1877 онд Цахарын сүрэг хошуунд төрж, 1946 онд Улаанбаатарт нас барсан. Монгол, манж хэл бичиг сайн мэддэг. Энэ хоёр хэлээр аль алинаар нь шүлэг бичдэг байлаа. Түвд сонгодог бичиг гадарладаг, Хятад хэлээр чөлөөтэй ярьдаг байсан. Одоо энэ хүний Богд хааны засгийн газарт бичсэн өргөдөл Монголын ахмад сэхээтний хувийн цуглууллагад байдгаас хэд хэдийг уншиж танилцахад зохиогч Монголын сонгодог бичгийн зүй тогтол, монгол хэлний үгийн сангийн баялгийг эзэмшиж чадсанаа илт харуулсан байлаа. Жо амбаны гэрийн номын санд түүний зохиосон монгол, манж хэлээр бичсэн шүлгүүд, баялаг сайхан номын хамт хувьсгалын эхний ширүүн жилүүдэд үрэгдсэн. Одоо өөрийнх нь хувийн зардлаар хэвлүүлсэн: “Зарлигаар тогтоосон гэти чуан лү (эрхтэн тус бүрийг тэмдэглэсэн бичиг”, “Хүүхэд төрөхүйг хамгаалах, нарийн чухал бичиг” болон фүлингаагийн бичсэн “Их монголын улсын Юань улсын судар” зэрэг зохиолын эхэнд бичсэн “оршил” үлджээ. Үүнээс зохиогчийн мэдлэг боловсрол хэр зэрэг болохыг харж болно. Манж хэлээр бичсэн шүлэг өчүүхэн хэсэг үлджээ. Онгодын Жамъяан гүний хүсэлтээр нийслэл хүрээнд байхдаа нянхядын түн жян ган мүү бичгийн дотроос монголын түүхэнд холбогдох зүйлийг түүвэрлэн орчуулсан нь одоо Улсын Төв Номын санд бий. “Шинээр орчуулсан Зи Ки Түн Жян Ган Мүү Чян бян бичиг” (гар бичмэл, нийт дөрвөн дэвтэр) зохиолын төгсгөлд манж хэлээр тухайн орчуулгад эндүүрэл ташаарал тохиолдвол сэтгэл харамгүй засан залруулахыг эрдэмтэн мэргэдэд хандан хүссэн шүлэглэл байна.

Америкийн монголч эрдэмтэн О.Латтимор, Бельгийн монголч эрдэмтэн А. Мостаэрт, түүхч Жүэ Хүн Мүү, Дагурын Цэнд гүн, Судар бичгийн хүрээлэнгийн дарга О.Жамъян, эрдэмтэн Ж.Цэвээн нартай ойр дотно харилцаатай байсан, О.Жамъян, Ж.Цэвээн нарын зохиолын нэлээд нь Жо амбаны гэрийн номын санд байсан ба О.Жамъян, Ж.Цэвээн нартай захидал бичгээр харилцдаг байлаа.

Эцэст тэмдэглэхэд алтан сургуул шүлгийн зохиогчийн тухай түүний эх зохиолын бичмэл болон дармал олон хувилбарын зүйлийг

эрдэм шинжилгээний түвшинд тусгай сэдэв боловсруулан судлах явдал зүй ёсоор шаардагдан буйг цаашид анхаарах болов уу.

Эшлэл зүүлт

1. Содном, Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв-“Шинжлэх ухаан” №12-13, УБ, 1946.61-62 дахь талд.

Ц. Дамдинсүрэн, Хуучин уран зохиолын доторх ардчилсан чиглэл-“Шинжлэх ухаан” № 1, 1995. УБ, Монгол уран зохиолын дээж зуун билэг оршив, УБ, 1959, 556.

Д.Цагаан, Л.Цэнд “Монголын уран зохиол, УБ, 1958, 110-115 дахь талд.

Д.Цагаан, шүлэгч Данзанванжил (1854-1907). Монголын уран зохиолын тойм, гуравдугаар дэвтэр, XIX-XX зууны үе, ред.Ц.Дамдинсүрэн. УБ, 1968, 118-129. Эрдэнэтогтох, гарамгай шүлэгчин Данзанванжил ба түүний шүлгийн тухай. "Гүлрэнсэ, Данзанванжил, Хэшигбат" Хөх хот, 1959, 38-48.

Г.И.Михайлов, Монголын уран зохиолын өв уламжлал, Москва, 1968, 140-147 орос хэлээр)
В.Хайссиг. Ишданзанванжил хийгээд түүний сурган сэнхрүүлэх шүлэг -"Монголын уран зохиолын түүх", Висбаден, 1972 он, 1 боть. 575-590. Герман хэлээр), Намжилцэвээн, Буянбат, Ишданзанванжил ба түүний сургаал шүлэг -"Монгол уран зохиолын түүх" дээд сургуулийн сурах. 1984. . 566-576.

Д.Цэрэнсодном, Монголын уран зохиол, XIII-XX зууны эх; Улаанбаатар, 1987. 382-387. Ринчингаваа, Монгол бичиг соёлын түүхийн туршилт тэгэхэ. Хөх хот. 1990, 341-347.

Я.Баатар. Жо амбаны намтраас үүдээд..., 1994 оны 5-р сарын 7-ны өдрийн “Улаанбаатар” сонины №86/545/

Ж.Төмөрцэрэн, эрдэмтэн Ж.Цэвээний номын нөхөр Жо амбан гэж хэн байв? 1994 оны 9-р сарын 3-ны өдрийн “Нийслэлийн сонин бичиг”-ийн № 35/6049/

2. Ерэн хоёр шүлэгт дөрвөн бүлэгтэй шинэ зохиолын сургаал. Нийслэл хүрээ, 1913. Зарлигаар соёрхсон буян ивээгч сүмийн гэгээний айлдсан гүнгийн зуугийн гэгээний сургаал оршив. 1922 он (нийслэл хүрээ). Гүнгийн зуугийн гэгээний алтан сургааль нэгэн дэвтэр оршив. Улаанбаатар, 1928. Гүнгийн зуугийн гэгээний сургаал, Шин Жин. 1943, Гүнгийн зуугийн гэгээний сургаал, Мүгдэн, 1950, Ц.Дамдинсүрэн, “Монголын уран зохиолын дээж зуун билэг оршив”, Улаанбаатар, 1959, 548-556. Эрдэнэтогтох, “Гүлрэнсэ, Данзанванжил, Хэшигбат" Хөх хот, 1959, 49-69.

Сайнжаргал. Шарилдай “Зарлигаар соёрхсон буян ивээгч гүнгийн зуу хийдийн мэргэн гэгээн Ишданзанванжилийн шүлэг таван зуун бадаг оршив”. 1979 тосон бар), Ишданзанванжилын шүлгүүд, Бээжин. 1984, 17-126.